



**НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
УЛААНБААТАР НЭГТГЭЛ ОНӨААТҮГ
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2016 оны 07 сарын 08 өдөр

Дугаар A/64

Улаанбаатар хот

Хөрөнгө зарцуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2, 20.1.10 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2013 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн 100 дугаар тогтоолоор батлагдсан "Нийтийн үйлчилгээний Улаанбаатар нэгтгэл" ОНӨААТҮГ-ын дүрмийн 6.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Үндэсний их баяр наадам, Ази Европын дээд түвшний 11 дэх удаагийн уулзалт зохион байгуулагдах өдрүүдийн, зохион байгуулалтын нэмэлт арга хэмжээний зардалд 4 952 000 /Дөрвөн сая есөн зуун тавин хоёр мянган/ төгрөг зарцуулсугай.

2. Дээрх зардлыг байгууллагын өөрийн орлогоос гарган санхүүжүүлэхийг Санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч /Д. Мөнх-Эрдэнэ/-д зөвшөөрсүгэй.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, хүний нөөцийн удирдлагын хэлтсийн дарга /Б.Мөнх-Оргил/-д даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Д.ЭНХСАЙХАН